



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 09 дугаар сарын 11

Дугаар 18/01

Баян-Өндөр сум

Г Хуралдааны дэг батлах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.9 дэх хэсэг 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус XVIII хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.

2.Хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хуралдаанд оролцогчдод үүрэг болгосугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны  
09 дүгээр сарын 11-ний өдрийн Ээлжит бус XVIII  
хуралдааны 18/01 дүгээр тогтоолын хавсралт

## АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС XVIII ХУРАЛДААНЫ ДЭГ

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит бус XVIII хуралдаан 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 09:00 цагт аймгийн Нутгийн удирдлагын ордны А.Амарын нэрэмжит их танхимд эхэлнэ.

2. Хурлын хуралдаанд аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн ЗДТГ-ын дарга, ИТХ-ын болон ЗДТГ-ын газар, хэлтсийн дарга нар, холбогдох агентлагийн удирдлага, мэргэжилтнүүд, газрын дарга, холбогдох мэргэжилтнүүд, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд оролцоно.

3. Аймгийн ИТХ-ын Ээлжит бус XVIII хуралдааны дэд даргад Төлөөлөгчдөөс нэр дэвшүүлж санал хураалтаар сонгуулна.

4. Хэлэлцэж байгаа асуудлаар гарах шийдвэрийн төслийг эцэслэн боловсруулах зорилгоор Редакцын комиссыг 3 хүртэлх Төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулна. Редакцын комиссын анхдугаар хурлыг хуралдааны удирдлагын зүгээс хийлгэж, даргыг сонгуулан хуралдаанд мэдэгдэж, ажиллахад нь зориулж бэлтгэсэн хавтсыг холбогдох материалын хамт хүлээлгэн өгч, тусгайлан бэлдсэн байранд урьж суулган ажилд нь оруулна.

5. Утга агуулгын болон ажлын уялдаа холбоог харгалзан тухайн асуудлыг шаардлагатай бол нэг багц асуудал болгон хэлэлцэж, асуулт хариулт, санал шүүмжлэлийг нэг мөр явуулж болно.

6. Хуралдаанд оролцож байгаа Төлөөлөгчдийн ирцийг mIsp.mn программаар бүртгэнэ.

7. Тухайн асуудлаар асуулт асуух, санал хэлэх Төлөөлөгчдийн нэrsийг хуралдааны удирдлагын зүгээs Misp.mn программаар урьдчилан авч дараалалд оруулна. Төлөөлөгчид тус программын санал гэсэн цэс дээр даран өөрийн нэрээ урьдчилан өгнө.

8. Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын Төлөөлөгч зориудаар хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно. Хуралдаанд зориудаар оролцоогүй буюу орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

9. Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар уг хэлэх хугацаа төлөөлөгч тус бүрд эхний удаа 3 хүртэл минут, хоёр дахь удаа 1 хүртэл минут байна. Тухайн хэлэлцэж буй асуудалтай холбогдолгүй асуулт асуух, санал хэлэхийг хориглоно.

10. Төлөөлөгч асуулт асуух, уг хэлэхдээ бүдүүлэг уг хэрэглэх, бусдын нэр төрийг гутаах, доромжлох, гутгэхийг хориглоно.

11.Төлөөлөгч дэгийн 10, 11 дугаар заалтуудыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт заасны дагуу арга хэмжээ авч болно.

12.Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар эцсийн шийдвэр гаргах, асуулт, хариулт, санал, шүүмжлэлийг таслахдаа санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

13.Хэлэлцэж байгаа асуудлаар цөөнх болсон Төлөөлөгчдийн үндэслэл, саналыг сонсож, дахин нэг удаа санал хураалт явуулж болно.

14.Асуулт асуух, уг хэлэх, санал шүүмжлэл гаргах зөвшөөрлийг хуралдааны удирдлага олгож, тогтоосон хугацааг баримтална.

15.Санал, шүүмжлэлийг хуралдааны удирдлагад бичгээр өгч болно. Бичгээр өгсөн санал шүүмжлэлийг хуралдааны удирдлага танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Редакцын комисст шилжүүлнэ.

16.Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Намын бүлэг завсарлага авч болох бөгөөд завсарлагын хугацаа эхний удаа 1 цаг, хоёр дахь удаа 30 минут хүртэл байна. Завсарлага авснаас хойш бүлгээс тухайн асуудалд нэгдсэн байр суурь илэрхийлж хуралдаанд оролцно.

17.Намын бүлэгт олгосон завсарлагын хугацаа сунгах шаардлага гарвал хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд тогтоосон хугацааг чанд баримтална.

18.Төлөөлөгч нь хуралдаанаар хэлэлцэх асуудал болон шийдвэрийн төслийг боловсруулах, шийдвэр гаргахад оролцох ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл аймгийн ИТХ-ын дарга болон аймгийн ИТХ-ын эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэл гаргана.

19.Хуралдааныг 2 цаг тутам 15 минутын завсарлагаатайгаар явуулна.

20.Өдрийн их завсарлага 1 цаг байна.

21.Хуралдаан тухайн ажлын өдөр багтахгүй бол үргэлжлүүлэх аль эсвэл дараачийн өдөр шилжүүлэх асуудлыг санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

22.Хуралдааны мэдээллийг орон нутгийн "NBHD" телевиз шууд дамжуулна. Мөн орон нутгийн бусад телевиз, сайт зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан иргэдэд хүргэх боломжоор ханган ажиллана.

23.Хуралдааны үед иргэдтэй харилцах 7035-0494 дугаарын утас ажиллана. Иргэдтэй харилцах утаснаас ирүүлсэн хувь хүний нэр төртэй холбоотойгоос бусад хэлэлцэж буй асуудалтай холбоотой саналыг багцлан хуралдаанд танилцуулж, шаардлагатай бол холбогдох албан тушаалтнаар хариу тайлбар хэлүүлнэ. Харин хэлэлцэж буй асуудалтай хамааралгүй иргэдийн ирүүлсэн хүсэлт, саналыг хуралдаанд танилцуулахгүйгээр шууд холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

24.Хуралдааны дарга хэлэлцэх асуудлыг хуралдааны дэгийн дагуу амжилттай явагдаж өндөрлөснийг дүгнэж, хуралдааныг хаасныг мэдэгдэнэ.

**25.Хуралдааны тэмдэглэлийг ИТХ-ын ажлын албаны хурлын зохион байгуулалт, хууль эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн хөтөлнө.**

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС XVIII ХУРАЛДААН**